



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/136

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “д”, “Барилгын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн Газар, БХБЯ-наас Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Аймаг, сумын төвийн бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ж.Мөнхчулуун	(Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Э.Чагнаадорж	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
	Н.Гантулга	(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
	Я.Мажаасүрэн	(Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга)
	Р.Мөнхтогтох	(Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч)
	Д.Сэргэлэнбаатар	(Дундговь-Ус ОНӨҮГ-ын ерөнхий инженер)
	Б.Рэнцэндорж	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
	Э.Энхмэнд	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Хоёр. “Аймаг, сумын төвийн бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т эхний ээлжинд бүтээн байгуулалтыг эхлүүлэх боломжтой дэд бүтцийн ажлуудын техник эдийн засгийн үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж, тооцоо судалгаа гарган Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны зөвлөх багт хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010386